

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР
ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ӨМА-2024/26-14-ШТА-ГА

**СУМДЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО ХАРИЛЦАН АДИЛГҮЙ
БАЙГАА НЬ ҮР ДҮНД НӨЛӨӨЛЖ БАЙНА.**

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор Г.Амарзаяа
Утас: 70533552 Цахим хаяг: Amarzaya@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ БҮРДҮҮЛЖ ХУВААРИЛСАН БАЙНА	5
1.1 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон байна	5
1.2 Батлагдсан зарим төсөл, арга хэмжээ иргэдээс авсан саналын жагсаалтад ороогүй байна	7
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦДОГГҮЙ БАЙНА	9
2.1 Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөт хугацааны дагуу хэрэгжүүлэхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна	9
2.2 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил сангийн хөрөнгийн үр дүнг бууруулж байна	10
2.3 Зарим төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглахгүй байна	11
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН БАЙНА	14
3.1 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх шаардлагатай байна	14
3.2 Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээг төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг дутуу оруулсан байна	15
ОНХС-ын талаарх иргэдээс авсан судалгааны үр дүн	17
ДҮГНЭЛТ.....	18
ЗӨВЛӨМЖ.....	19
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТХ	Төсвийн тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ЗҮГСЖ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
НААҮГ	Нийтийн аж ахуйн үйлдвэрийн газар

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	ОНХНС-аас олгох шилжүүлгийг эх үүсвэрээр	5
Хүснэгт 2	ОНХС-ын эх үүсвэр сум бүрээр	6
Хүснэгт 3	2023 оны батлагдсан төсөв, ОНХС-ын төлөвлөгөө	7
Хүснэгт 4	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт	15
Дүрслэл 1	ХАА-нд баримталсан журмын харьцуулалт /мөнгөн дүнгээр/	9

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад түүврийн арга ашиглан Өмнөговь аймагт Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам”;

- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Засгийн газрын 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Т.Хишигбат, Г.Амарзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ БҮРДҮҮЛЖ ХУВААРИЛСАН БАЙНА.

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон байна.

1.1 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг,
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр,
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг,
- Малын тоо толгойн албан татварын орлого

1.2 Дээрх эх үүсвэрүүдээс татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдлийн эх үүсвэр сумуудад 2020-2023 онд төлөвлөгөө, гүйцэтгэл гарч байгаагүй байна. Энэ нь ОНХС-ын бүрдүүлэлтийг дутуу хэрэгжүүлж, нөөцийг бүрэн ашиглахгүй байгаатай холбоотой байна. Иймд хуулийг хэрэгжүүлэх, сангийн хөрөнгийг нэмэх боломжийг судлах шаардлагатай байна.

1.3 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Өмнөговь аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 28,685.2 сая төгрөг байхаар баталсан байна.

Хүснэгт 1 Олгох шилжүүлгийг эх үүсвэрээр задалбал: /сая.төг/

№	Сумд	2023 оны ОНХНС болон улсын төсөв							
		ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг /ТТХ-ийн 60.2.1 орсон/		Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 100% /ТТХ-ийн 60.2.7 орсон/		Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50% /ТТХ-ийн 60.2.7 орсон/		"Тогтвортой амжиргаа-3" төсөл /ТТХ-ийн 59.1.3/	
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	Урамшуулал төлөв	гүйц
1	Баяндалай	471.5	471.5	21.9	21.9	12.3	12.3	74.7	74.7
2	Баян-Овоо	511.5	511.5	18.7	18.7	170.1	170.1	-	-
3	Булган	409.7	409.7	-	-	-	-	66.8	66.8
4	Гурвантэс	1,835.9	1,835.9	2.1	2.1	164.8	164.8	-	-
5	Мандаловоо	369.3	369.3	-	-	37.9	37.9	-	-
6	Манлай	770.1	770.1	36.8	36.8	71.3	71.3	119.0	119.0
7	Ноён	480.7	480.7	6.4	6.4	114.5	114.5	-	-
8	Номгон	741.0	741.0	14.1	14.1	74.5	74.5	-	-
9	Сэврэй	533.7	533.7	-	-	-	-	102.9	102.9
10	Ханбогд	1,955.1	1,955.1	35.5	35.5	468.3	468.3	-	-
11	Ханхонгор	386.6	386.6	1.9	1.9	52.2	52.2	-	-
12	Хүрмэн	433.4	433.4	16.5	16.5	19.5	19.5	82.0	82.0
13	Цогт-Овоо	400.6	400.6	49.0	49.0	15.0	15.0	61.6	61.6
14	Цогтцэций	1,167.4	1,167.4	9.2	9.2	145.4	145.4	169.0	169.0
15	Даланзадгад	1,980.1	1,980.1	-	-	0.1	0.1	-	-
16	Аймгийн төв	12,446.5	12,023.4	212.2	212.2	1,345.9	1,345.9	-	-
	Дүн	24,893.0	24,470.0	424.5	424.5	2,691.8	2,691.8	676.0	676.0

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.4 Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээр 28,262.2 сая төгрөг олгож, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд зааснаас 423.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

1.5 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

1.6 Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 13/11 дугаар тогтоолоор татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр 5,000.0 сая төгрөг, уул уурхайн хандиваар орох орлогыг 5,000.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт 9,000.0 сая төгрөг аймгийн ОНХС-д төвлөрүүлсэн байна.

1.7 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9¹-д заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт 5,000.0 сая төгрөг төлөвлөснөөс Эрдэнэс Таван толгой ТӨХК-ийн хандивын орлого 4,000.0 сая төгрөг төвлөрч 1,000.0 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

1.8 Сумдын ИТХ-ын тогтоолоор Ханбогд сум бусад орлогод 50.0 сая төгрөг, Цогт-Овоо сум 29.0 сая төгрөг төлөвлөж бусад сум төлөвлөөгүй. Малын тоо толгойн албан татварыг 13 сум 30.0-160.0 сая төгрөгийн хооронд төлөвлөж Баян-Овоо, Гурвантэс сумд төлөвлөөгүй байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

1.9 Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ын нийт эх үүсвэрийг 45,396.5 сая төгрөгөөр баталсан байна. Сумдаас Цогтцэций сум хамгийн их буюу 2,922.1 сая төгрөгийн, Цогт-Овоо сум хамгийн бага буюу 660.6 сая төгрөгийн төсөв тус тус баталсан байна.

Хүснэгт 2 ОНХС-ын эх үүсвэр сум бүрээр:

/сая.төг/

№	Сумд	Нийт эх үүсвэр	
		төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Баяндалай	896.8	863.9
2	Баян-овоо	1,583.2	1,583.2
3	Булган	697.5	674.7
4	Гурвантэс	2,556.3	2,556.3
5	Мандал-Овоо	661.4	657.5
6	Манлай	1,585.2	1,581.9
7	Ноён	1,279.7	1,279.7
8	Номгон	1,014.7	1,059.5
9	Сэврэй	831.9	805.4
10	Ханбогд	2,896.8	2,886.7
11	Ханхонгор	731.1	670.7
12	Хүрмэн	719.7	650.8
13	Цогт-Овоо	660.6	704.6
14	Цогтцэций	2,922.1	2,894.7
15	Даланзадгад	2,354.8	2,347.8
16	Аймаг	24,004.6	23,640.4
	Нийт	45,396.5	44,857.7

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.10 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ын зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих,

¹ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэхээр заасан байдаг.

1.11 Сум бүрд харилцан адилгүй төсөв хуваарилагдаж байгаа байдал мөн эх үүсвэрийг нэмэх талаар сумдын Засаг дарга нар бодит арга хэмжээ авч ажиллахгүй байгаа зэрэг нь журмын зорилго хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

1.12 Цаашид төсөв боловсруулж батлахдаа ОНХС-ын хөрөнгийг нэмэгдүүлэх боломжийг хуулийн хүрээнд судлан арга хэмжээ авч орон нутгийн хөгжилд оруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.2 Батлагдсан зарим төсөл, арга хэмжээ иргэдээс авсан саналын жагсаалтад ороогүй байна.

1.13 Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 13/11 дугаар тогтоолоор ерөнхий нэрээр 20 төсөл, арга хэмжээнд нэр төрлөөр задалбал 49 төсөл, арга хэмжээнд 24,004.6 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

1.14 Сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 327 төсөл арга хэмжээнд 21,391.8 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Хүснэгт 3 2023 оны батлагдсан төсөв, ОНХС-ын төлөвлөгөө

№	Сумд	Нийт орлого	Нийт зарлага	ОНХС-ын	
				ТАХ-ий тоо	Дүн
1	Баяндалай	2,614.2	2,614.2	31	896.8
2	Баян-Овоо	3,921.6	3,921.6	18	1,583.2
3	Булган	2,262.4	2,262.4	26	697.5
4	Гурвантэс	28,779.2	28,779.2	14	2,556.3
5	Даланзадгад	26,636.9	26,636.9	15	661.4
6	Мандал-Овоо	2,011.9	2,011.9	30	1,585.2
7	Манлай	3,812.8	3,812.8	26	1,279.7
8	Номгон	2,703.5	2,703.5	26	1,014.7
9	Ноён	3,353.50	3,353.50	27	831.9
10	Сэврэй	2,744.2	2,744.2	8	2,896.8
11	Ханбогд	237,425.1	237,425.1	16	731.1
12	Ханхонгор	2,269.2	2,269.2	22	719.7
13	Хүрмэн	2,130.6	2,130.6	25	660.6
14	Цогт-Овоо	2,384.9	2,384.9	21	2,922.1
15	Цогтцэций	62,386.3	62,386.3	22	2,354.8
16	Аймаг	940,800.9	940,800.9	49	24,004.6
	Нийт	1,326,137.2	1,326,137.2	376	45,396.5

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.15 Аймаг сумдын ОНХС-ын хөрөнгөөр төсөл арга хэмжээнд зарцуулах зардлын хэмжээ нийт төсвийн зарлагын 3.4 хувийг эзэлж байна. Энэ нь зарлагыг хэмнэх замаар ОНХС-ын хөрөнгийг нэмэх боломж байгааг харуулж байна.

1.16 Аймгийн хэмжээнд 637 төсөл арга хэмжээнд давхардсан тоогоор цахим хэлбэрээр 1,581, ярилцлагаар 758, цаасаар 140,973 санал авч 367 төсөл арга хэмжээ хамгийн өндөр санал авч хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.17 Иргэдээс санал авч эрэмбэлсэн жагсаалтад ороогүй ОНХС-ын үйл ажиллагааны журмын 4.3.2²-т заасантай нийцэхгүй нийт 9 төсөл арга хэмжээнд 2,775.6 сая төгрөг баталсан зөрчил илэрсэн. Үүнд:

- Мандал-Овоо сум 3 төсөл арга хэмжээнд 135.0 сая төгрөг,
- Ханбогд сум 2 төсөл арга хэмжээнд 1,865.8 сая төгрөг,
- Хүрмэн сум 1 төсөл арга хэмжээнд 4.2 сая төгрөг,
- Цогтцэций сум 3 төсөл арга хэмжээнд 770.6 сая төгрөг тус тус баталсан байна.

1.18 Энэ нь хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлдоггүй, эх үүсвэрийг буруу төлөвлөсөн зэргээс шалтгаалсан байна. Иймд дээрх сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлжээ.

1.19 Сайн жишээ: Сэврэй сумын Засаг дарга ЗДТГ-н ажилчид жилийн эцсийн мал тооллого болон бусад ажлаар багуудын бүх айлаар явахдаа ОНХС-н саналын хуудсыг тараан өгдөг байна. Сарын дараа тараан өгсөн бүх саналын хуудсаа цуглуулан авч эрэмбэлсэн байна

1.20 Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/3 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2/4 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталсан байна.

1.21 Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6 бүлэг, 28 зорилт, 211 арга хэмжээг багтаасан байна. Үүнд “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого 16, Итгэл-эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлого 36, Ирээдүй-Боловсрол, инновацын хөгжлийн бодлого 32, Хөгжил- эдийн засаг, нутгийн үйлдвэрлэлийн бодлого 69, Шударга-хүний эрх, эрх чөлөө, засаглалын бодлого 31, Байгаль орчин, хариуцлагатай уул уурхай, ус, бэлчээрийг хамгаалах бодлогын хүрээнд 26 заалтыг төлөвлөжээ.

1.22 Аймаг сумдын ОНХС-ын хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг хангахад чиглэсэн байна. Гэвч зарим сум эх үүсвэр хязгаарлагдмал байхад хэт олон төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь сангийн үндсэн зорилгыг хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

1.23 Цаашид сумдын Засаг дарга нар сум бүр ойролцоо эх үүсвэрээр харилцан адилгүй тоотой төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаад судалгаа, дүн шинжилгээ хийж орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, арга хэмжээ төлөвлөх шаардлагатай байна.

1.24 Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 45,396.5 сая төгрөгийн 376 төсөл, арга хэмжээнд Төсвийн тухай хуульд заасан шалгууртай холбоотой зөрчил илрээгүй, Мөн ОНХС-ын чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээг тусгаагүй байна. Харин ОНХС-ын хөрөнгөөр хийх зарим төсөл, арга хэмжээ нь зардлын шинж чанартай 37 төсөл, арга хэмжээнд 928.9 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦДОГГҮЙ БАЙНА.

2.1. Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөт хугацааны дагуу хэрэгжүүлэхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

2.1. Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 45,396.5 сая төгрөгийн 376 төсөл, арга хэмжээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс 7,370.0 сая төгрөгийн 70 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.

2.2. Энэ нь зарим сумын ОНХС-аар хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төсөв хүрэлцэхгүй, холбогдох зөвшөөрөл гараагүй, урилга явуулсан ч оролцогч ороогүй, худалдан авах ажиллагааг оройтож зарласан зэргээс шалтгаалсан байна. Цаашид төлөвлөлтийн шаардлагад нийцсэн техник эдийн засгийн үндэслэлийг сайжруулах шаардлагатай байна.

2.3. Мөн худалдан авах ажиллагааны 2023 оны тайлангаас харахад нийт төсөл, арга хэмжээний 27 хувийг 1 дүгээр улиралд, 36 хувийг 2 дугаар улиралд, 19 хувийг 3 дугаар улиралд, үлдсэн 18 хувийг 4 дүгээр улиралд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.4. Төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн захирагч нар энэ нөхцөл байдалд анхаарч, үр дүнтэй арга хэмжээ авахгүй бол 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1³ заалтын хэрэгжилт хангагдахгүй байх үр дагавар гарч болзошгүй байна.

2.5. Тайлант онд төлөвлөсөн төсөл арга хэмжээний 81.4 хувьд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/


Дүрслэл 1 ХАА-нд баримталсан журмын харьцуулалт /мөнгөн дүнгээр/

10%

Гэрээ шууд байгуулах аргаар 3,680.5 сая төгрөгийн 164 төсөл арга хэмжээг шалгаруулсан байна.

9%

Харьцуулалтын аргаар 3,479.7 сая төгрөгийн 66 төсөл арга хэмжээг шалгаруулсан байна.



80

Нээлттэй тендер шалгаруулалт аргаар 30,661.4 сая төгрөгийн 75 төсөл арга хэмжээг шалгаруулсан байна.

1%

Хязгаарлагдмал тендер шалгаруулалт аргаар 60.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг шалгаруулсан байна.

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

³ батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

2.6. Дээрхээс харахад худалдах авах ажиллагаа зарласан мөнгөн дүнгийн 80 хувьд нь НТШ-ын журам ашигласан боловч нийт төсөл арга хэмжээний тоогоор 53.6 хувьд шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь зарим сумд сангийн хөрөнгийг хэт жижиглэж төсвийн байгууллагын урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь үр өгөөжийг бууруулж байна

2.7. ОНХС-ын 2023 оны хөрөнгөөр нийт 376 төсөл арга хэмжээнд 45,396.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж жилийн эцсийн гүйцэтгэлээр 306 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулан баталгаажсан гүйцэтгэлээр 34,014.4 сая төгрөг олгосон байна.

2.8. Ноён сумын ОНХС-ын хөрөнгөөр хийсэн 20.0 сая төгрөгийн “Зураг төсвийн багц” ажлыг хүлээн авч гэрээний үнийн дүнг олгохдоо 40.0 сая төгрөг буюу 20.0 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁴ дахь хэсэгтэй нийцэхгүй байна. Иймд илүү олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2.2 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил сангийн хөрөнгийн үр дүнг бууруулж байна.

2.9. Аймаг сумдын ОНХС-ын хөрөнгөөр нийт 376 төсөл арга хэмжээнд 45,396.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 306 төсөл арга хэмжээнд 38,026.4 сая төгрөгийн гэрээ байгуулж 7,370.0 сая төгрөгийн 70 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байгаа нь төлөвлөгөөний 22.9 хувь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүйг харуулж байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

2.10. Энэ нь аймаг, сумд нь төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээг нэмж баталснаас худалдан авах ажиллагааны хугацаа оройтсон, огт зарлаагүй, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй, захиалагч гэрээгээ цуцалсан зэрэг шалтгаанаар зарим төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2.11. Цаашид сумдын Засаг дарга нар огт хэрэгжээгүй төсөл арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийж төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

2.12. Бүрэн хэрэгжсэн 36,276.6 сая төгрөгийн 286 төсөл арга хэмжээнд түүврийн арга ашиглан зарим төсөл арга хэмжээний үр дүнг шалгахад Сэврэй сумын ОНХС-ын хөрөнгөөр санхүүжүүлсэн 33.0 сая төгрөгийн “Сургуулийн анги танхим тохижуулах мэдээлэл зүйн кабинет” ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 20 ширхэг компьютер нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй нийлүүлэгдсэн байна.

2.13. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг Сэврэй сумын Засаг даргад хүргүүлсэн.

⁴ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2.3 Зарим төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглахгүй байна.

2.14. Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгөд түүврийн арга ашиглан зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад 2 сумын 1,000.0 төгрөгийн 7 хөрөнгийг ашиглахгүй, хамгаалалтгүй байна. Үүнд:

- Баяндалай сумын "Гэр бүл хөгжлийн төв" НААҮГазрын их засварын ажил хийсэн ч байшингийн 5 цонх хагарсан байгааг өмчлөгч байгууллага засаж янзлаагүй ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна.

Зураг 1 Цонхны хагарсан байдал



- Баяндалай сумын нийтийн нойл ашиглалт хамгаалалтгүй, бохир, ус алдсан, ажиллуулах хүнгүй байна.

Зураг 2 Нийтийн нойл



- Сэврэй сумын ОНХС-ын хөрөнгөөр хийсэн тоглоомын талбай эвдэрсэн, зарим тоглоом нь алга болсон байна.

Зураг 3 Эвдэрсэн тоглоом



- Арьс шир, талх нарийн боовны тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд: Ажиллуулах хүн нь бодисоос харшсан шалтгаанаар арьс ширний үйлдвэрээ ажиллуулж чадахгүй шинээрээ хадгалагдаж байна.

Зураг 4 Ашиглахгүй байгаа хөрөнгө



2.15. Зарим сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн төсөл, арга хэмжээ нь ОНХС-ын үндсэн зорилгод нийцсэн бусад сумдад сайн жишээ болохоор төсөл арга хэмжээ болсон байна. Тухайлбал:

- Баяндалай сум Шүдний кабинет байгуулах, шүдний тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд суурин болон явуулын үзлэг эмчилгээ хийх боломжтой болсон байна. Сумын 144 иргэн шүдний нарийн мэргэжлийн эмчилгээ авч, 97 хүүхэд үзлэг оношилгоонд хамрагдсан байна.

Зураг 5 Тоног төхөөрөмж



- Сэврэй сум гэрэлтүүлэг, камержуулалт нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Нийлүүлэгдсэн камер нь дүрслэл сайн холдуулж, ойртуулдаг орчноо бүтэн эргэж хянадаг байна. Мөн гэрэлтүүлэг цахилгаан зарцуулалт бага байна.

Зураг 6 Гэрэлтүүлэг, камер



- Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр Номгон, Цогт-Овоо, Сэврэй сумыг дулааны найдвартай эх үүсвэрээр хангах ажлын хүрээн уурын зуух шинээр барих, Номгон, Баяндалай, Цогт-Овоо, Ноён, Сэврэй сумын төвийн дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээг шинээр барих, Манлай сумын төвийн гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөх зэрэг ажлууд нь ард иргэдээс сайн үнэлгээ авсан ОНХС-ын зорилготой нийцсэн байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН БАЙНА.

3.1 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх шаардлагатай байна.

3.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

3.2 Аймаг сумын ИТХ сангийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүн хяналт хийгээгүй, хийсэн эсэх нь нотлогдохгүй, баримтжуулаагүй байна.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний чанар, байдалтай танилцаж, зөвлөмж өгсөн гэх боловч үр дүнг ИТХ-аар хэлэлцээгүй, тухайн төсөл, арга хэмжээний нийгэмд авчрах үр өгөөжийг тооцоогүй байгаа нь ИТХ-ын зүгээс хийгдэх хяналтын үр дүнг бууруулж байна.

3.4 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба сумдын ОНХС-ын 2023 оны 1-9 сарын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлсэн байна. Хяналтаар сум тус бүрд зөрчил арилгах зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Энэ нь Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын зөрчил бага байгаад нөлөөлсөн байна.

3.5 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн хэдий ч чанар үр дүнд хангалттай хийгээгүй нь Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хяналтаар харагдаж байна.

3.6 Аймаг сумдын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг ГХБХБГ болон сумдын ЗДТГ-ын томилогдсон албан тушаалтнууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.7 Сангийн хөрөнгөөр шууд гэрээ байгуулсан 3,825.3 сая төгрөгийн 164 төсөл арга хэмжээнд захиалагч хяналт хийгээгүй, хийсэн нь нотлогдохгүй байна. Мөн Булган сум 36.8 сая төгрөгийн “Сургуулийн дотор камержуулалт”, 30,0 сая төгрөгийн “Цахим хурлын тоног төхөөрөмж”-ийн 2 төсөл арга хэмжээнд захиалагч хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь төсөл арга хэмжээний үр дүнг бууруулах эрсдэлтэй байна. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг Булган сумын Засаг даргад хүргүүллээ.

3.8 Сумдын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд мэргэжлийн бус сумын ЗДТГ-ын даргын томилсон албан тушаалтнууд хяналт хэрэгжүүлж байгаа нь хяналт хангалтгүй хэрэгжүүлэх үндсэн шалтгаан болж байна.

3.9 ГХБХБГ тусгай мэргэжлийн орон тооны хүртээмжээс шалтгаалан зарим төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг хангалтгүй хийсэн байна.

3.10 ОНХС-ын хөрөнгөөр хийх ажлын тоо, санхүүжилт жил бүр өсөж байгаа тул захиалагчийн хяналтыг сайжруулж мэргэжилтнүүдийн чадвар, хүний нөөцөд анхаарах шаардлагатай байна.

3.11 Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ын 2021 оны хөрөнгийн зарцуулалтад 1 төлбөрийн акт, зөрчил арилгах 13 албан шаардлага, 5 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

Зөрчлийн төрөл	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Хэрэгжилт хувь	Тоо	Хэрэгжилт хувь	Тоо	Хэрэгжилт хувь
Зориулалт бусаар зарцуулсан	-	-	1	100	-	-
Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн	-	-	2	100	1	100
Төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн	1	100	-	-	-	-
ОНХС-ийн УМС-д мэдээллийг байршуулаагүй, зөрүүтэй мэдээлсэн	-	-	1	100	1	100
Дутуу буюу чанаргүй хийгдсэн	-	-	2	100	-	-
Бүртгэл тайланд тусгаагүй	-	-	-	-	1	100
Санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй	-	-	1	100	-	-
Захиалагчийн хяналт тавиагүй	-	-	2	100	-	-
Бусад	-	-	4	100	2	100
дүн	1	100	13	100	5	100

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь ТАБ-ын 2023 оны жилийн эцсийн статистик мэдээ

3.2 Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээг төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг дутуу оруулсан байна.

3.12 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2⁵-д заасны дагуу 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сумд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т журамд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.13 Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.9⁶-д заасны дагуу аймаг, сумдын 2021 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж Сангийн яаманд аймгийн Засаг даргын 2024.03.07-ний өдрийн 01/499 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

3.14 ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл арга, хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг сумдын ИТХ-аар тогтоол гаргуулж холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгүүлсэн байна.

⁵ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.

⁶ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

3.15 Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 33,085.4 сая төгрөгийн 194 хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэж авсан байна.

3.16 Орон нутгийн өмчийн газар болон сумдын санхүү албаны дарга нар нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтөд тавих хяналт сайжирсантай холбоотойгоор шинээр бий болсон хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй зөрчил гараагүй байна

3.17 ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зардлын шинж чанартай, үндсэн хөрөнгөд бүртгэх боломжгүй 928.9 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээ байгаа нь төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөнтэй холбоотой байна.

3.18 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 10.2⁷-т заасны дагуу tusuv-ogonnutag.mof.gov.mn сайтад Өмнөговь аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг оруулсан байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Удирдлагын мэдээллийн системд 8 сум 15 төсөл арга хэмжээг дутуу оруулсан
- Аймаг, 15 сум удирдлагын мэдээллийн системд 227 төсөл арга хэмжээг огт оруулаагүй байна. /Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас/

3.19 Энэ нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод үүрэгдүүлж өгөөгүйгээс орхигдсон, сумдын албан тушаалтнууд журмын мэдлэг дутмагаас болсон байна

3.20 Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

3.21 ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1.1, 6.3.9 дэх заалтуудаар шилэн дансны shilendans.gov.mn цахим сайтад байршуулахаар тусгайлан зааж өгсөн байна. Шилэн дансны нэгдсэн цахим сайтад ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулж ажилласан эсэхийг тулган үзэхэд зөрчил илрээгүй.

3.22 ОНХС-ын аудитын хугацаанд иргэдээс цахим хэлбэрээр судалгаа авсан. Судалгаанд аймгийн хэмжээнд 10 сумын 575 иргэн хамрагдсан байна. Судалгааны дүн дараах байдлаар гарсан байна.

⁷ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААРХ ИРГЭДЭЭС АВСАН СУДАЛГАА

Нийт санал
575




Харьяалал

-Манлай 87
-Сэврэй 59
-Ноён 27
-Номгон 12
-Даланзадгад 69
-Цогт-овоо 63
-Баян-овоо 54
-Булган 19
-Гурвантэс 103
-Цогтцэций 82

Орон нутгийн хөгжлийн сангийн
талаар хэр мэдээлэлтэй


Хангалтгүй 294
Хангалттай 229
Мэдэхгүй 52

Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?



Засаг дарга, хороодын хэсгийн ахлагч.158
Мэдээлэл авдаггүй.107
Нэг цэгийн үйлчилгээ, иргэний танхимын ажилтан.38
Орон нутгийн мэдээллийн самбар, цахим орчин.196
Удирдлагын мэдээллийн системээс.76

Та орон нутгийнхаа 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
бий болсон төсөл арга хэмжээний талаар мэдэх үү?



Зарим төсөл арга хэмжээг мэднэ.347
Огт мэдэхгүй.75
Сайн мэднэ.153

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 онд баталсан хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүтээн
байгуулалтууд нь орон нутгийн хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болсон уу?



Та орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн
байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарт ямар үнэлгээ өгөх вэ?



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Өмнөговь аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 28,685.2 сая төгрөг байхаар баталсан байна
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд 376 төсөл, арга хэмжээнд 45,396.5 сая төгрөг баталсан байна.
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг 7,370.0 сая төгрөгийн 70 төсөл арга хэмжээнд зарлаагүй байна.
- Нийт төсөл арга хэмжээний тоогоор 53.6 хувьд шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь зарим сумд сангийн хөрөнгийг хэт жижиглэж төсвийн байгууллагын урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь үр өгөөжийг бууруулж байна.
- Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд алдаа зөрчил гарч байгаа нь хөрөнгө оруулалтыг үр дүнг бууруулж байна.
- Удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээг төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг дутуу оруулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Сумдын Засаг дарга нарт:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэхэд анхаарах.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/126

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-д даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР